

**”ЦЭВЭР ТӨРИЙН ТӨЛӨӨ” МОНГОЛЫН НОГООН НАМЫН
2012 ОНЫ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Эрхэм зорилго

Эх орныхоо байгалийн унаган төрх, уламжлалт өв соёлоо хамгаалан, Монгол хүний үнэ цэнийг дээдлэх төрийн бодлогыг хэрэгжүүлж, хойч үедээ цэвэр байгаль орчин, хөгжингүй Монгол орныг өвлүүлэхэд оршино.

Үзэл баримтлал

Байгальд ээлтэй оюун санаа, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн үзэл санааг баримтлан, даяарчлалыг технологи, мэдээллийн салбарт хүлээн зөвшөөрч, соёл, гүн ухаан, улс төр, нийгэм, үндэсний баялагийн хүрээнд төрт ёсны уламжлалаа дээдэлж, дангаарчлалыг эрхэмлэнэ.

Уриа: Эрхэм ариун амьдралын төлөө цэвэр төрийг цогцлоон байгуулцгаая!

Зорилт

- Монгол хүн эх орондоо байгаль, оюун санаа, улс төр, нийгэм, эдийн засаг, бизнесийн цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Монгол хүн эх орныхоо баялагийн эзэн нь байна.
- Монгол орноо цөмийн аюулгүй бүс нутаг болгох санал санаачлагыг олон улсын хэмжээнд тунхаглана.
- Монгол улсаа байгаль экологийн цэвэр хүнс үйлдвэрлэгч, улмаар экспортлогч орон болгоно.
- Монгол улсынхаа өрх гэр, иргэн бүрийн амьдралын чанарыг дээшлүүлж, чинээлэг дундаж давхрагын эгнээг өргөжүүлнэ.

Цэвэр төр

Эх оронч үзлийг дээдэлсэн, шударга замаар байгуулагдсан, хуулийг сахиулан биелүүлдэг, улс төрийн хариуцлага, иргэдийн хяналтын тогтолцоог ханган бүрдүүлсэн засаглалын бүтцийг “Цэвэр төр” гэж ойлгоно.

Цэвэр төр нь:

1. Шударга сонгуулиар байгуулагдсан байна.
2. Үндэсний эрх ашгийг дээдэлдэг байна.
3. Хуулийг ягштал сахин, биелүүлэгч байна.

4. Иргэд сонгогчдод ил тод нээлттэй байна.
5. Эрх үүргийн тэнцвэрийг хангадаг байна.
6. Хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлдэг байна.
7. Авилга, мөнгөн эрх ашгаас хараат бус байна.
8. Ард түмнээ дээдэлж, чанартай төрийн үйлчилгээг хүргэгч байна.
9. Төрийн албан хаагч нь ёс суртахууны өндөр шаардлага хангадаг байна.

Төр аливаа шийдвэр гаргахдаа шинжлэх ухааны үндэс, нарийн мэргэжлийн судалгаа, дүгнэлт, үндэсний эрдэмтэн мэргэдийн зөвлөмж, бүх нийтийн хэлэлцүүлэг, шууд ардчилалын оролцоо зэрэг олон талт хүчин зүйлээр үнэлэх зарчмыг мөрдлөгө болгож бодлого, үйл ажиллагаагаа цэвэршүүлнэ.

Цэвэр төрийг цогцлоон байгуулахдаа “Цэвэр нийгэм”, “Цэвэр эдийн засаг”, “Цэвэр байгаль орчин” гэсэн гурван үндсэн ойлголтод тулгуурлах бөгөөд эдгээр гурван тулгуур баганыг бат бөх, тогтвортой байлгахыг эрхэмлэнэ.

ЦЭВЭР ТӨРИЙГ ЦОГЦЛООИ БАЙГУУЛАХ “ГУРВАН ЦЭВЭР” ХӨГЖЛИЙН БОДЛОГО

НЭГ. ЦЭВЭР НИЙГЭМ

- 1.1 Монгол улсаа эрүүл, хүнлэг, эх оронч, түүх, соёлоо мэддэг, ардын уламжлалт зан заншлаа амьдрал ахуйдаа хэвшүүлсэн, эцэг эхээ хайрладаг, ахмад, нялхсыг асардаг, ханийн итгэлийг даадаг, өндөр ёс суртахуунтай, өргөн мэдлэг боловсрол, чадвар, туршлагатай, эх орныхоо хөгжил дэвшил, хувь заяаг түшилцэх зүтгэл, сэтгэл дүүрэн иргэдтэй болгохыг эрмэлзэнэ.
- 1.2 Монгол улсын хувьд төр цэвэр байх нийгмийн үндэс нь улс төрийн намууд гишүүнчлэлгүй байх явдал хэмээн үзэж холбогдох хуулийн заалтуудад өөрчлөлт оруулна.
- 1.3 Шууд ардчилалын зарчмыг Үндсэн хуулинд тусгаж орон нутгийн ард иргэд өөрсдийн амьдрал ахуй, хувь заяатай холбоотой чухал асуудалд эцсийн шийдвэр гаргадаг эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 1.4 Нийгэмд шудрага ёсыг хангах суурь үндэс нь ерөнхий боловсрол олгох сургалтын орчин, нөхцөлийг тэгшитгэх явдал хэмээн үзэж МУ -ын Үндсэн хуулийн 16.7 заалтыг үндэслэл болгон ерөнхий боловсролын системд хувийн

- хэвшлийн оролцоог хязгаарлан, өсвөр хойч үедээ гарааны ижил нөхцөлд боловсрол эзэмшүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, мөрдлөгө болгоно.
- 1.5 Сүү цагаан идээ, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мах, гурил, гурилан бүтээгдэхүүнээ 100 хувь дотооддоо үйлдвэрлэж хүн амаа эрүүл хүнсээр хангах бодлого хэрэгжүүлнэ.
- 1.6 Импортын хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналт, стандартыг боловсронгуй болгож, хөгжингүй орнуудын түвшинд хүргэнэ.
- 1.7 Эрүүлийг хамгаалах бодлогын хүрээнд өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзэл баримтлалыг хэрэгжүүлж нийтийн биеийн тамирыг бүх шатанд хэвшүүлнэ.
- 1.8 Архи, тамхи, төрөл бүрийн мансууруулах хорт зуршилаас ард иргэд, хойч ирээдүйгээ хамгаалж архидалт, мансууралын эсрэг хөтөлбөр, санаачилгыг эрчимжүүлэн дэмжинэ.
- 1.9 Улаанбаатар хотын агаарын бохирдол, замын түгжрэлийг бууруулах үүднээс нийтийн тээврийн үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи болох “Агаарын метро” -ний үйлчилгээ нэвтрүүлэх урьдчилсан нөхцөл бүрдүүлэхийг эрмэлзэнэ.

ХОЁР. ЦЭВЭР ЭДИЙН ЗАСАГ

- 2.1 Экологийн баримжаатай нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг амьдралд хэрэгжүүлэх үүднээс эдийн засгийн тооцоонд экологийн татварыг тусгах хууль эрх зүйн орчин бүрдүүлэхийг эрмэлзэнэ.
- 2.2 Уламжлалт нүүдлийн соёл иргэншлийнхээ байгальд ээлтэй дэвшилтэт шинжийг хадгалсан, хариуцлагатай зах зээлийг бэхжүүлсэн, ногоон эдийн засгийн бодлого барьсан, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн орон байна гэдэг томъёололыг төрийн бодлого болгоно.
- 2.3 Эх орны байгалийн баялаг ашиглах, олборлохдоо гадаадын хөрөнгө оруулалт дайчлах тохиолдолд Монгол улсын засгийн газар хамгийн багадаа 51 хувийг эзэмших нөхцөл хадгалагдах хууль эрх зүйн орчинг баталгаажуулан мөрдүүлнэ.
- 2.4 МУ-ын Үндсэн хуулийн 6.1 заалтыг үндэс болгон эх орны байгалийн баялагийн 10 хувийг төрийн мэдлийн тусгай санд хуримтлуулж ирээдүй хойч үе, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын эх үүсвэр бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ.

- 2.5 Аж ахуйн нэгжийн албан татварыг орлогын хэмжээгээр шатлалтай болгож хэт их орлоготой иргэн, аж ахуйн нэгжид 80 хүртэл хувийн ашгийн албан татвар ногдуулах хуулийг санаачлан хэрэгжүүлнэ.
- 2.6 Эдийн засгийн шударга өрсөлдөөнийг хангах үүднээс гадаад, дотоодын хөрөнгө оруулагч байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд гарааны ижил нөхцлийг хангах хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 2.7 Аливаа бизнесийн үйл ажиллагааг нэмүү өртөг шингээлтийн түвшин болон уг үйл явцын хүрээлэн буй орчинд хор хөнөөл багатай технологид суурилсан байдлыг үндэслэн урамшуулах тогтолцоо бүрдүүлэхийг эрмэлзэнэ.
- 2.8 Нар, салхи, ус, газрын гүний дулаан, био масс зэрэг нөхөн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглан түүний нийт эрчим хүчний үйлдвэрлэлд эзлэх хувийг эрс нэмэгдүүлнэ.
- 2.9 Экологийн аялал жуулчлалыг хөгжүүлж Монгол улсын нэр хүндийг өргөхүйц аялалын “брэнд” бүтээгдэхүүн үйлчилгээг төрийн бодлогоор бий болгоно.
- 2.10 Уул уурхайн эрхийн бичиг болох лицензийн наймааг хуулиар хориглож, худалдагдсан байгаа лицензүүдийг анх авсан байгууллага, аж ахуй нэгж, хувь хүний нэр дээр биш бол хураан авах хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 2.11 Өрх бүрийг үйлдвэрлэгч болгох бодлого боловсруулан хэрэгжүүлж, дотоодын нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад дотоодын зах зээлд нийлүүлэх борлуулалт маркетингийн нэгдсэн бодлогыг төрийн дэмжлэгээр хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 2.12 Оюуны болон урлаг, ур чадварын багтаамж өндөртэй бүтээгдэхүүн үйлчилгээний ДНБ -нд эзлэх хувь хэмжээг эрчимтэй нэмэгдүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ЦЭВЭР БАЙГАЛЬ ОРЧИН

- 3.1 МУ-ын Үндсэн Хуулийн “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэсэн заалтыг амьдралд бодитой хэрэгжүүлнэ.
- 3.2 Олон улс, бүс нутгийн хэмжээний байгаль орчноо хамгаалах бодлого, үйл ажиллагаанд идэвхтэй оролцохын зэрэгцээ Монгол улсын газар нутгийн 30

- хүртэл хувийг Улсын тусгай хамгалалтанд авах төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.3 Экологийн боловсрол олгох үзэл баримтлалыг бүх нийтийн хүртээл болгоно.
- 3.4 Цөмийн эрчим хүчийг ашиглахгүй, уран, бусад цацраг идэвхит байгалийн баялгийг олборлохгүй, цөмийн хаягдлыг эх орондоо байршуулахгүй, цацрагийн хор хөнөөлгүй улс болохоо олон улсад тунхаглаж, үндсэн хууль, бусад холбогдох эрх зүйн баримт бичигт тусгана.
- 3.5 Айл өрх, албан газар, аж ахуйн нэгж бүр өөрийн эзэмшил газартаа ногоон байгууламжтай байхыг хуульчилж мөрдүүлнэ.
- 3.6 Байгаль орчныг хамгаалах чиглэлээр өмнө гарсан хуулиудыг хөгжлийн ирээдүйн чиг хандлагатай уялдуулан сайжруулахын зэрэгцээ нэгэнт гарсан хуулиудыг заавал дагаж мөрдүүлэх хатуу механизмыг бий болгон, “бохирдуулагч нь төлөгч”, “ашиглагч нь хамгаалагч” байх үзэл санааг хэрэгжүүлнэ.
- 3.7 Уул уурхайн нөхөн сэргээлтийн зардлыг олборлолт эхлэхээс өмнө төрийн санд төвлөрүүлж, нөхөн сэргээлтэнд шаардагдах нэмэгдэл зардлыг тухай бүрд нь гаргуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 3.8 Экосистемийн хямрал түүнээс үүдэлтэй экологийн гамшиг нүүрлэх аюулаас ард иргэдээ хамгаалах хууль эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгож хяналт, хариуцлагын тогтолцоог өндөржүүлэн чангатгана.
- 3.9 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хуулийн хүрээнд албажуулан хяналтыг чангатгана.
- 3.10 Хүрээлэн буй орчинд үзүүлэх хөр нөлөө өндөртэй зарим үйл ажиллагааг хугацаа болон ашиглалт, стандартын шаардлагаар хязгаарлах бодлого баримтална.
- 3.11 Байгаль орчин, экологид ээлтэй техник, технологи нэвтрүүлсэн хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагыг 2.4 -т заасан сангаас урамшуулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.12 Улаанбаатар хотын экосистемийн хямрал буюу агаар, хөрс, усны бохирдолыг зогсоох үүднээс дэвшилтэт технологид тулгуурласан дэд бүтцийн төвлөрсөн бус шийдэл бүхий дулааны хэмнэлттэй, экологид ээлтэй хувийн орон сууцаар ард иргэдээ хангах нэгдсэн бодлого боловсруулж, ажил

хэрэг болгох нөхцөлийг хангаж тохь тухтай амьдралын орчныг бүрдүүлэх замаар агаарын болон орчны бохирдолыг арилгана.

- 3.13 Туул голын экосистемийг сэргээн хамгаалж, Тэрэлж орчимын хэсэгт хөв цөөрөм буюу усан сан байгуулах замаар Улаанбаатар хотын ундны усны хангамжид гадаргын усыг ашиглах боломжийг бүрдүүлнэ.

Цэвэр төрийг цогцлоон байгуулах тулгуур багана болсон “Цэвэр нийгэм”, “Цэвэр эдийн засаг”, “Цэвэр байгаль орчин” гэсэн гурван үндсэн хүрээний зорилтуудыг хангах замаар “Гурван цэвэр” -ийн бодлогыг хэрэгжүүлж байгаль орчинд ээлтэй оюун санаа, нийгэм, эдийн засгийн хөгжил, бүтээн байгуулалтыг цогцлоон байгуулах бөгөөд үргэлжлүүлэн хэрэгжүүлбэл зохилтой өмнөх засгийн газрын үйл ажиллагааг улам төгөлдөржүүлэн залгамжлахыг бид эрмэлзэх болно.

Монгол улсын үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулах, гамшиг дагуулах онц ноцтой үр дагавар бүхий дараахь үйл ажиллагааг хатуу хориглон хуульчилна.

- Үндэсний уламжлалт аман болон бичгийн өв соёл, нүүдлийн соёл иргэншил, зан заншил, үндэсний хувцас, эд хэрэгсэл, хүнс, зэр зэвсэг, хөгжмийн зэмсэг зэрэг үнэт зүйлсээ дээдлэн үзэж энэ бүхэнд ямар нэг хэлбэрээр эрсдэл учруулах, гутаан үгүйсгэх, бүрхэгдүүлэхийг
- Уран болон цацраг идэвхит бусад ашигт малтмал олборлох ашиглахыг
- Хөвсгөл аймаг дахь Фосфоритын орд газар олборлолт, ашиглалт явуулахыг
- Баян-Өлгий аймаг дахь Асгатын мөнгөний орд газар олборлолт, ашиглалт явуулахыг
- Говийн бүсийн гүний усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг
- Газрын ховор элементийн олборлолт, ашиглалтыг
- Гар аргаар алт олборлох, шороон орд ашиглахыг
- Онц ноцтой химийн хорт бодис импортлох, уул уурхайн олборлолтод ашиглахыг
- Нэн ховордсон болон ховордсон амьтан, ургамал биологийн зүйлс агнах, ашиглахыг

тус тус хатуу хориглоно.

Монгол улс өнө мөнх оршиг!

МОНГОЛЫН НОГООН НАМ